



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 1783

Улаанбаатар хот

Улирлын чанартай хоол үйлдвэрлэл, худалдаа
үйлчилгээ эрхлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8.2.10.13 дэх дэд заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолын хавсралтын 3.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэхээр Нийслэлийн Засаг даргаас дэвшүүлсэн зорилго, арга хэмжээ, үүрэг даалгаврын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн боломжтой талбайд улирлын чанартай, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ явуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дээрх худалдаа үйлчилгээг явуулах боломжтой байршлыг Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн хавсралтаар баталсугай.

3. Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулан, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж, ажиллах, хог хаягдлыг тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, хороодын Засаг дарга (Н.Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Зөвшөөрөгдсөн нийтийн эзэмшлийн талбайд худалдаа, үйлчилгээг эрхлэх, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт хангасан хоол, хүнсний худалдаа, үйлчилгээг шаардлагат нийцсэн стандартын дагуу үйлчилгээ явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид хяналт тавьж, ажиллахыг дүүргийн менежер, Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл (Г.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/117 дугаарт захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

1225010253

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
878 дугаар захирамжийн хавсралт



ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ ТАЛБАЙД
УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ БАЙРШИЛ

Д/д	Хороо	Байршил	Төрөл
1.	1	Төв талбайн урд хэсэг	Зайрмаг худалдах, тоглоом тоглох үйлчилгээ
2.	1	Орон сууцны 1,2 дугаар байрны дунд урд хэсэг	Барааны худалдаа
3.	1	Орон сууцны 4 дүгээр байрны баруун талын талбай	Хүнсний ногоо, жимс жимсгэнэ
4.	2	Орон сууцны 3,4,5,6,7,8,9 дүгээр байрнуудын дунд	Барааны худалдаа
5.	2	"Сити саун"-ы урд талд Хэнз хонгор ХХК-ны хойд тал	Барааны худалдаа
6.	2	94 дүгээр сургууль, хорооны цогцолбор барилгын дунд	Хүнсний ногоо, жимс жимсгэнэ
7.	2	Орон сууцны 3,4,5,6,7,8,9 дүгээр байрнуудын талбай	Зайрмаг худалдах, тоглоом тоглох үйлчилгээ
8.	2	Багахангай өндөрлөг	Хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ